

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 09/198
 дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт



“АЛСЫН ХАРАА – 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ
 БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРААС ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 09 дүгээр сарын 10

Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр | Зорилтот түвшин үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|-------------------------------------|---|--|------------------|--|--|---|-------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | |
| ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ | | | | | | | |
| 1 | 9.1.Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно. | 9.1.18.Хотын хэмжээнд бүх насны иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, биеийн тамир, спортын барилга байгууламжийг төлөвлөн байгуулна. | 2020-2050 | - | Төрөлжсөн талбайн тоог 108 болгоно. Спортын барилга байгууламжийн хүртээмжийг 64 мкв-д хүргэнэ. | Стандарт шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын гадна талбайг 2020-2024 оны эхний хагас жилд 88-өөр нэмэгдүүлж 182 болсон байна. Үүнд 2020 онд 1, 2021 онд 7, 2022 онд 4, 2023 онд 36, 2024 оны 09 дүгээр сарын байдлаар Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/490 дүгээр захирамжаар Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан ажиллаж 40 талбай ашиглалтад оруулсан. Нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 63,5мкв болсон байна. Үүнд Сонгинохайрхан дүүргийн Толгойт хөгжлийн төвийн спорт заал, 29-р хороонд City спорт заал, 20-р хороонд ОБ спорт заал, Сүхбаатар дүүргийн 159-р сургуулийн спорт заал, Анполло фитнес төв, Наран спорт төв, Баянзүрх дүүргийн 26-р хороонд Чухаг спорт төв, Хан-уул дүүргийн MINT sport Club, В3 NBA спорт заал, Emart спорт заал, Наадам клуб, Сүхбаатар дүүргийн Shine sport center спорт заал тус тус ашиглалтад орсон бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Налайх дүүргийн спорт цогцолбор 98%, Багахангай дүүргийн спорт цогцолбор 70%, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор 85%, Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 70%-тай үргэлжилж байна. | 70% |
| | | | | | | Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1046 дугаар “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт | |

| | | | | | | |
|----|---|--|-----------|---|---|-----|
| 2. | 9.3.Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй, хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө. | 9.3.48.Тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, томоохон спортын наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30,000-40,000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж байгуулна. | 2021-2030 | - | байрших 30.0 га газарт “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон боловч тухайн газар нь Байгаль орчны яаманд олгосон газруудтай давхцалтай байсан тул Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07 тоот тушаал, Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны 36 дугаар тушаалаар дэд ажлын хэсгүүд байгуулагдан газрын маргаан, зөрчлийг шийдвэрлэхээр ажиллаж байгаа ч газрын асуудал эцэслэн шийдэгдээгүйн улмаас зураг төсөв эцэслэн батлагдах, хөрөнгө шийдвэрлэх боломжгүй болсон. Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 315 дугаар тогтоол гарч хэрэгжиж байсан бөгөөд 2023 оны 162 дугаар тогтоолоор тус тогтоол хүчингүй болгосон байна. Олон Улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн шинээр барих асуудал нь бодлогын баримт бичгүүдэд туссан 2020-2024 оны хүрэх түвшиндөө бүрэн хүрэх боломжгүй байгаа тул бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалтуудыг хасах санал гарган 2023 оны 3/222 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргүүлж ажилласан. | 30% |
|----|---|--|-----------|---|---|-----|

| | | | | | | | |
|---|--|--|-----------|-----------------------|---|---|-----|
| 3. | 9.5.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ. | 9.5.14.Олон улс, тив, дэлхийн томоохон наадмуудыг хүлээн авч зохион байгуулах шаардлага хангасан спортын барилга байгууламжийг барина. | 2021-2030 | Улсын төсвөөс 1,748.0 | Налайх дүүргийн спорт цогцолборыг ашиглалтад оруулна. | 2024 оны 09 дүгээр сарын байдлаар нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 63,5мкв байна. 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн Налайх, Багахангай, Баянзүрх дүүргийн спорт цогцолборуудыг ашиглалтад оруулахаар төлөвлөж Багахангай дүүргийн 2 дугаар хорооны спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Алтан шар говь" ХХК шалгарч 2022 онд 500.0 сая, 2023 онд 815.6 сая, 2024 онд 1,100.0 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлын 70 хувийг гүйцэтгэж карказ, гадна өрлөгийн ажил дууссан, сантехникийн ажил эхэлсэн бол Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Бүрд констракшн" ХХК ажиллаж 15.0 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр байгуулж 98 хувьтай улсын комиссын шийдвэрээр дуусгавар болж ашиглалтад оруулахаар хүлээгдэж байна. Баянзүрх дүүргийн спортын ордны бүтээн байгуулалтын ажил 85 хувьтай 2024 онд 2.58 тэрбум төгрөг тусгаж үерийн далангийн хийх ажил үргэлжилж байна. | 70% |
| Хэрэгжилтийн дундаж 56.6 хувьтай үргэлжилж байна. | | | | | | | |

ТАНИЛЦСАН:
ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР, ТАЙЛАН
МЭДЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Ж.ТАНБОЛД

М.ЦОГЗОЛМАА

Н.СҮНЖИДМАА

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 08/198 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

“АЛСЫН ХАРАА – 2050” УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БАРИМТ
БИЧИГТ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР ТУССАН
АЖЛЫН 2020-2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2024 оны 09 дүгээр сарын 10



Улаанбаатар хот

9.1.18. Хотын хэмжээнд бүх насны иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, биеийн тамир спортын барилга байгууламжийг төлөвлөн байгуулна.


Нийслэлийн хэмжээнд 2024 оны 09 дүгээр сарын байдлаар стандарт шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын гадна талбай 182 байна. Үүнд:

2019 оны суурь түвшин 94 байсан бол 2020 онд Багануур дүүргийн Гүн галуутай сургуулийн гадна хөлбөмбөгийн талбай байгуулагдаж стандарт шаардлагад нийцсэн спортын гадна талбай 95 болсон.



2021 онд нийслэлийн Баянгол дүүргийн 4, 8, 12, 13, 2 дугаар хороодод, Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороонд 3х3 сагсан бөмбөгийн 6 талбай байгуулагдсан бол 24 дүгээр сургуулийн гадна хөлбөмбөгийн 1 талбайг шинэчлэн тохижуулсан, шинээр байгуулагдаж стандартын гадна талбайн тоо 101 болсон.



2022 онд нийслэлийн хэмжээнд стандарт шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын гадна талбай 4-өөр нэмэгдэж 105 болсон буюу Хан-уул дүүргийн 8 дугаар хороонд хөлбөмбөгийн талбай бүхий техникийн төв, Сүхбаатар дүүргийн 2-р сургууль, Хан-Уул дүүргийн 34, 52-р сургуулиудын гадна талбайг хөлбөмбөгийн талбайгаар шинэчлэн тохижуулсан.



2023 онд 36 талбайгаар нэмэгдэж 140 буюу Чингэлтэй дүүргийн 57, Сонгинохайрхан дүүргийн 67-р сургуулийн спорт талбай мөн нийслэлийн Засаг даргын санаачилгаар 3х3 сагсан бөмбөгийн 34 талбайг 2022 оноос тохижуулж эхлэн 2023 оны 06 дугаар сард ашиглалтад оруулсан.



2024 оны 09 дүгээр сарын байдлаар Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/490 дүгээр захирамжаар Нийслэлийн Хот тохижилтын газар хариуцан 40 талбай ашиглалтад оруулсан.

Баянгол дүүргийн Оюуны ундраа цогцолбор сургуулийн гадна талбайг Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран ОУ-ын стандарт шаардлага хангасан хөлбөмбөгийн талбай байгуулахаар үерийн далан байгуулах ажлыг гүйцэтгэсний дараа тохижуулахаар хүлээгдэж байна.

Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороонд стандарт шаардлага хангасан хөлбөмбөгийн талбай байгуулахаар газар чөлөөлөлтийн ажил бүрэн дуусч гүйцэтгэгчээр шалгарсан "Аглуут" ХХК нь тус бүтээн байгуулалтын суурийн ажлыг эхлүүлж нийт ажлын 5 хувийг гүйцэтгээд байна.

Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороонд Нийслэлийн Онцгой байдлын ерөнхий газрын аврах ангийн спорт талбайг шинэчлэх ажлыг "Стандарт холдинг" ХХК хариуцан 15 хувьтай үргэлжлүүлж байна.

9.3.48.Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, томоохон спортын наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30,000-40,000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж байгуулна.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1046 дугаар "Газар эзэмших эрх олгох тухай" захирамжаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрших 30.0 га газарт "Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн" байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон боловч тухайн газар нь Байгаль орчны яаманд олгосон газруудтай давхцалтай байсан тул Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07 тоот тушаал, Барилга хот байгуулалтын


сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны 36 тоот тушаалаар дэд ажлын хэсгүүд байгуулагдан газрын маргаан, зөрчлийг шийдвэрлэхээр ажиллаж байгаа ч газрын асуудал эцэслэн шийдэгдээгүйн улмаас зураг төсөв эцэслэн батлагдах, хөрөнгө шийдвэрлэх боломжгүй болсон.

Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн байгуулах талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 315 дугаар тогтоол гарч хэрэгжиж байсан бөгөөд 2023 оны 162 дугаар тогтоолоор тус тогтоол хүчингүй болгосон байна.

Олон Улсын жишигт нийцсэн 30.000-40.000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн шинээр барих асуудал нь бодлогын баримт бичгүүдэд туссан 2020-2024 оны хүрэх түвшиндөө бүрэн хүрэх боломжгүй байгаа тул бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалтуудыг хасах санал гарган 2023 оны 3/222 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн.



9.5.14. Олон улс, тив, дэлхийн томоохон наадмуудыг хүлээн авч зохион байгуулах шаардлага хангасан спортын барилга байгууламжийг барина.

Нийслэлийн хэмжээнд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2019 онд 60мкв байсан бол 2020 онд 60.5мкв, 2021 онд 61м2, 2022 онд 62мкв 2023 онд 63,5мкв, 2024 оны эхний хагас жилд 63.5мкв байна. Үүнд:



2020 оны 06 дугаар сард Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороонд 1000 хүний суудалтай спорт цогцолборын А, В блок ашиглалтад орсон.

2021 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд битүү дээвэртэй "Steppe Arena" өвлийн спортын ордон ашиглалтад орсон.




2021 онд "Gan sports center" 6,000 мкв талбайтай Монголын хамгийн том спорт комплекс ашиглалтад орсон.





2022 онд Баянгол дүүргийн 15-р хороо хороонд 650 хүний суудалтай спорт цогцолбор ашиглалтад орсон.

2022 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Баянгол дүүргийн 3-р хороонд 3000 хүний суудалтай "UG Arena" спорт ордон ашиглалтад орсон.




2022 онд Баянзүрх дүүргийн 26-р хороонд 576 мкв талбай бүхий Чухаг спорт төв ашиглалтад орсон.

2023 онд Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо нүхтийн зам дагуу 508 мкв талбай бүхий MINT sport Club ашиглалтад орсон.



2023 онд Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо Говийн зам дагуу 600мк талбай бүхий В3 NBA спорт заал ашиглалтад орсон.



Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд 833 мкв талбай бүхий Emart спорт заал ашиглалтад орсон.


2023 онд Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд 812 мкв талбай бүхий Наадам спорт клуб ашиглалтад орсон



2023 онд Сүхбаатар дүүргийн 11-р хороо 672 мкв талбай бүхий Хангай хотхонд Shine sport center спорт заал ашиглалтад орсон.



2023 онд Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд 540 мкв талбай бүхий "ОБ" спорт заал ашиглалтад орсон.





2023 онд Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороонд Толгойт хөгжлийн төвийн 1 давхарт спорт заал ашиглалтад орсон.


2023 онд Сонгинохайрхан дүүргийн 29-р хороонд 800 мкв талбайтай “City” спорт заал ашиглалтад орсон.




Баянхошуу дэд төв буюу Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороонд баригдах 650 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 70 хувьд хүрсэн байна.




Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд баригдаж буй спорт цогцолборын гүйцэтгэгчээр “Атимос трейд” ХХК шалгарч 11.014,8 сая төгрөгийн төсөвт өртгөөр барихаар 2014 оноос эхлүүлж 85 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. 2023 оны улсын төсөвт 2,700.0 сая төгрөг тусгагдсанаас бөгөөд үүнээс 1,200.0 сая төгрөг нь усан бассейнд, 1,500.0 сая төгрөг нь дотор засал болон далангийн ажилд төсөвлөгдөж ажлын гүйцэтгэлийг үнэлж 2,300.0 олгосон.



2024 оны 09 дүгээр сарын байдлаар үерийн далангийн ажлын "Ажил эхлэх зөвшөөрөл"-ийг Хотын стандарт, хяналтын газарт албан тоот явуулж зөвшөөрлөө авсан бөгөөд газар шорооны ажил эхэлсэн байна.




Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй спорт цогцолборын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Бүрд констракшин" шалгарч 2012 оноос эхлэн 2024 оны 08 сард дуусган ашиглалтад өгөхөөр ажиллаж байна. 2024 оны 04 дугаар сарын 15-ны өдөр Спорт цогцолборын барилгад Улсын комисс ажиллаж хугацаатай үүрэг даалгавар өгч улмаар 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөр улсын комиссын дүгнэлт гарсан. Биеийн тамир, спортын улсын хороо, дүүргийн Засаг дарга нар зөвшилцөн Налайх дүүргийн спорт хороо 2024 оны 09 дүгээр сарын 1-нд нүүж үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна.



Нийслэлийн Багахангай дүүргийн 2 дугаар хороонд баригдаж буй спорт цогцолборын гүйцэтгэгчээр “Алтан шар говь” ХХК шалгарч нийт 2,412.9 сая төгрөгийн төсөвт өртгөөр барихаар 2022 оноос ажлыг эхлүүлж 2023 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар 75 хувийн гүйцэтгэлтэй барилгын ажил зогссон байна. 2023 оны төсөвт 815.6 сая төгрөг суугдсан бөгөөд 294.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2023 оны 06 дугаар сараас 12 дугаар сар хүртэл хоёр давхар спорт цогцолборын газар шорооны ажил, суурийн ажил, карказ, дотор өрлөгийн ажлыг 100 хувь дуусгаж, дотор өрөөнүүдийн хязгаарлалтын өрлөгийн ажлыг дуусгасан бол 2024 оны 09 дүгээр сарын байдлаар гадна, дотор сантехникийн ажил үргэлжилж байна.



ТАНИЛЦСАН:
ДАРГА

Ж.ГАНБОЛД

ТАЙЛАН ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

М.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН ГАРГАСАН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.СҮНЖИДМАА

